



ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ,
ГЕОДЕЗИ ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 07 сарын 10 өдөр

Дугаар 5/10

Улаанбаатар хот

Аймгуудын Газрын харилцаа, барилга, хот
байгуулалтын газрын зохион байгуулалтын бүтэц,
орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэл,
жагсаалтыг шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 377 дугаар тогтоолын 4.5 дахь хэсэг, Засгийн газрын 2022 оны 417 дугаар тогтоол, Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт”, “Төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2019 оны 276 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймаг, нийслэл дэх мэргэжлийн хяналтын байгууллагыг татан буулгаж, чиг үүрэг, орон тоог шилжүүлсэнтэй холбогдуулан “Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт”-ыг 1-21 дүгээр хавсралтаар шинэчлэн баталсугай.

2. Шинээр нэмэгдсэн, өөрчлөгдсөн албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн боловсруулж, баталгаажуулах ажлыг зохион байгуулахыг Захиргаа, удирдлага, хамтын ажиллагааны газарт даалгасугай.

3. Батлагдсан зохион байгуулалтын бүтэц, орон тоонд нийцүүлэн Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хүрээнд албан хаагчдыг томилон ажиллуулахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга нарт үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Газрын даргын 2019 оны Б/123 дугаар тушаал, 2021 оны Б/06 дугаар тушаал, 2021 оны Б/73 дугаар тушаал, 2022 оны Б/59 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



А.ЭНХМАНЛАЙ

1523010062

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргын 2023 оны 27 дүгээр сарын 20-ны өдрийн 270 дугаар тушаалын долоодугаар хавсралт



Дархан-Уул аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт

№	Албан тушаалын жагсаалт	Албан тушаалын ангилал, төрөл	Албан тушаалын зэрэглэл	Орон тоо
1	Газрын дарга	Ахлах түшмэл, Удирдах	T3-4	1
2	Захиргаа, хуулийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн	Дэс түшмэл, Гүйцэтгэх	T3-8	1
3	Газар, геодези, зураг зүйн улсын байцаагч	Дэс түшмэл, Гүйцэтгэх	T3-7	1
4	Барилгын техникийн хяналтын улсын байцаагч	Дэс түшмэл, Гүйцэтгэх	T3-7	1
5	Өргөх байгууламжийн хяналтын улсын байцаагч	Дэс түшмэл, Гүйцэтгэх	T3-7	1
6	Ерөнхий нягтлан бодогч	Гүйцэтгэх	TY-8	1
7	Мэдээллийн технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Дэс түшмэл, Гүйцэтгэх	T3-9	1
8	Албан хэрэг хөтлөлт хариуцсан ажилтан	Гүйцэтгэх	TY-5	1
9	Архивын ажилтан /нярав/	Гүйцэтгэх	TY-5	1
10	Жолооч	Гүйцэтгэх	TY-3	1
	Нийт			10
Газрын удирдлагын хэлтэс				
1	Хэлтсийн дарга	Дэс түшмэл, Удирдах	T3-6	1
2	Газар зохион байгуулалт, төлөвлөлт, газар өмчлөлийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн	Дэс түшмэл, Гүйцэтгэх	T3-8	1
3	Кадастрын асуудал хариуцсан мэргэжилтэн	Дэс түшмэл, Гүйцэтгэх	T3-9	1
4	Газрын татвар, төлбөр, үнэлгээний асуудал хариуцсан мэргэжилтэн	Дэс түшмэл, Гүйцэтгэх	T3-9	1
5	Геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн	Дэс түшмэл, Гүйцэтгэх	T3-9	1
6	Суурь судалгаа, газрын мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Дэс түшмэл, Гүйцэтгэх	T3-9	1
7	Газрын даамал	Дэс түшмэл, Гүйцэтгэх	T3-9	4
	Нийт			10
Барилга, хот байгуулалтын хэлтэс				
1	Хэлтсийн дарга	Дэс түшмэл, Удирдах	T3-6	1

2	Барилгын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн	Дэс түшмэл, Гүйцэтгэх	T3-8	1
3	Инженерийн дэд бүтцийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Дэс түшмэл, Гүйцэтгэх	T3-9	1
4	Барилгын материалын үйлдвэрлэл, лабораторийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Дэс түшмэл, Гүйцэтгэх	T3-9	1
5	Хот байгуулалтын кадастр, зураг төсөл, магадлалын асуудал хариуцсан мэргэжилтэн	Дэс түшмэл, Гүйцэтгэх	T3-9	1
6	Барилгын лабораторийн шинжээч	Гүйцэтгэх	TУ-6	1
	Нийт			6
	Бүгд			26